

Суралцагчдын англи хэлээр бичсэн цогцолборт хийсэн дүн шинжилгээ

Цээсэдийн Баясгалан 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Англи, герман хэлний тэнхимийн багш, магистр, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-03-31

Засварласан - Revised:
2024-04-11

Хэвлэгдсэн - Published:
2024-05-30

bayasgalan@msue.edu.mn

ORCID: [0009-0002-6499-2304](https://orcid.org/0009-0002-6499-2304)



© 2024, Author(s)

Хураангуй: Энэхүү судалгаа нь Монгол Улсын Боловсролын Их сургуулийн бакалаврын оюутнуудын бичсэн цогцолборын (догол мөр) бүтэц болон өгүүлбэрүүдийн нэгдмэл байдалд хийх дүн шинжилгээнд чиглэгдсэн болно. Судалгаа нь англи хэлний цогцолборын ерөнхийн бүтцийн хэсгүүдийг загвар болгон ашигласан. Судалгаанд нийт 6 оюутныг хамруулсан ба уг судалгааны мэдээлэлд оюутнуудын англи хэлээр бичсэн өөр өөр сэдэв бүхий цогцолбор багтсан болно. Судалгааны явцад оюутнууд цогцолборыг аливаа хэрэг явдлын тухай харьцангуй төгс санаа илэрхийлсэн нэгдмэл утга бүхий бүтэц гэдгийг ойлгодоггүй нь илэрсэн. Зарим оюутнуудын хувьд цогцолборын бүтцийг зөв зохион байгуулж бичих тал дээр бэрхшээлтэй тулгарч байв. Түүнчлэн оюутнууд цогцолбор бичихдээ тухайн сэдвээсээ хазайсан, онц чухал шаардлагагүй өгүүлбэрүүдийг бичих болон үйл явдлын дэс дарааллыг алдагдуулсан зэрэг алдааг гаргаж байсан. Оюутнууд цогцолборын дэмжих туслах болон дүгнэлт өгүүлбэрийг бичихдээ алдаа гаргаж байсан нь чиглүүлэгч өгүүлбэрийн гол үүргийг сайн ойлгоогүйтэй холбоотой байв.

Түлхүүр үг: бичих чадвар, чиглүүлэгч өгүүлбэр, дэмжигч өгүүлбэр, дүгнэлт өгүүлбэр

Удиртгал

Бичих чадвар бол харилцааны чухал хэсэг бөгөөд унших, ярих, сонсох чадваруудын нэг юм. Бусад чадваруудын нэгэн адил бичих нь харилцааны чухал хэсэг юм. Хүмүүс ихэвчлэн бичгээр харилцах шаардлагатай болдог. Бичих хийх шаардлагатай олон үйл ажиллагаа, ажил мэргэжил байдаг. Бүх хүнд хувийн захидал, тайлан, төлөвлөгөө гаргах, өргөдөл, нийтлэл, цахим шуудан, мөн нийгмийн харилцаанд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх гэх мэт өдөр тутмын үйл ажиллагаанд нь бичих чадвар хэрэг болдог билээ. Бичих нь заримдаа хувь хүний сахилга батыг ч төлөвшүүлдэг гэж үздэг бөгөөд шууд бус харилцааны үүрэг гүйцэтгэдэг хэлний чадвар юм.

Бичих нь хүний сэтгэн бодох чадварыг сайжруулж, бусад хэлний чадварыг хөгжүүлэхэд тусалдаг (A. D. Jayanti, 2019) учир оюутнуудын сурах ёстой англи хэлний хамгийн чухал ур чадварт тооцогддог. Иймд суралцагчид бичих чадвараа хангалттай хэмжээнд дадлагажуулж бичих чадвараа хөгжүүлэх хэрэгтэй. Дасгал даалгавар хийж гүйцэтгэснээр текстийг үр дүнтэй, зөв бичихэд түлхэц өгч магадгүй юм. Asiah, Ardian, and Amri (2020) нар оюутнууд өөрсдийн мэдрэмж, мэдлэг, санаагаа бичгээр илэрхийлж чаддаг тул бичих ур чадварыг сайжруулах нь нэн чухал гэж үздэг. Мөн түүнчлэн Ningsih (2016) бичих нь хүний уураг тахин дах мэдлэгийг бичгийн хэлбэрт шилжүүлэх нэг үйл ажиллагаа юм гэж мэдэгджээ.

Англи хэлний бичих чадварын онолын хэлбэр нь бичгийн загвар болтлоо хөгжсөн. Англи

хэлний зохион байгуулалт, хэв маяг нь эрдэм шинжилгээний бичгийн хэллэгийн лавлагаа болдог. Нэмж дурдахад англи хэлний дүрэм, үг хэллэг, бичих загваруудыг нь ихэнх эрдэм шинжилгээний бичвэрүүд даган мөрддөг. Англи хэлээр сайн бичих нь зөв дүрэм, зохион байгуулалтыг шаарддаг.

Оюутнуудын хувьд бичихдээ зорилгоо санаж, түүнд нийцэх жишээ баримтуудыг сонгохдоо эргэцүүлэн бодож, эдгээрийг хэрхэн хооронд нь уялдаа холбоотой болгох талаар тунгаах ёстой болдог. Latief, M.A. (1990)-ийн хийсэн англи хэлийг гадаад хэл (EFL) болгон суралцаж буй оюутнуудын англи хэлний бичих ур чадварыг үнэлэх судалгаанаас үзэхэд бичих чадварын хичээлд олон дахин хамрагдсан оюутнуудын чадвар сайжраагүй байв. Зарим оюутнууд англи хэлээр бичих төслийг эх хэлээрээ эхлэн бичээд дараа нь орчуулдаг байж.

Англи хэлээр сайн бичихийн тулд суралцагч зөвхөн англи хэлний дүрмийн дүрмийг төдийгүй англи хэлний ярианы зарчмуудыг сурах ёстой. Oshima and Hogue (1991) болон Budiharso (2005:2) “Уран илтгэл нь шулуун, тод бичгийн хэв маягийн жишиг болох сайн бичих урлаг юм” гэжээ. Англи хэлний стандарт бичвэр нь гол санааг хэрхэн хөгжүүлэн дэлгэрүүлэх үндсэн мэдлэгийг өгдөг тул цогцолборын онолыг судлах нь нэн шаардлагатай.

Англи хэлний цогцолбор

Цогцолборыг Stern, A.A. (1976) “Бүтцийн хувьд хамааралтай өгүүлбэрүүдийн дараалал” гэж тодорхойлсон. Warriner, J.E. (1988, хуудас 43) “Цогцолбор нь хоорондоо нягт холбоотой өгүүлбэрүүдийн бүлэг юм” гэжээ. Warriner, J.E. (1988), Stern, A.A. (1976) нар “Цогцолбор нь ижил төстэй өгүүлбэрүүдийн бүлэг” гэж үзжээ. Эдгээр тодорхойлолтууд нь ялангуяа уншигч нэг өгүүлбэр бүхий догол мөртэй таарах үед маргаан дагуулдаг. Тэд “Догол мөрийг нэг өгүүлбэрээс бүрдүүлж болох уу? гэж асуудаг. Хариулт нь тийм эсвэл үгүй гэсэн нөхцөл байдал байх нь ойлгомжтой. Хэрэв тийм бол яагаад Stern, A.A. (1976) болон Warriner, J.E. (1988) хоёулаа догол мөрийг “... холбоотой өгүүлбэрүүд” гэж тодорхойлсон бэ? Учир нь тэдний тодорхойлолтод ” догол мөр нь зөвхөн өгүүлбэрээс бүрдэх боломжгүй” гэж үзсэн байдаг. Langan, J. (2001, х. 5) догол мөрийг 150-200 орчим үгтэй богино өгүүлэл гэж үздэг бөгөөд энэ нь сэдэв өгүүлбэр гэж нэрлэгддэг нээлтээс бүрдэх ба дараа нь уг санааг дэмжих хэд хэдэн өгүүлбэрээс бүрддэг гэж тодорхойлсон байдаг.

Цогцолбор нь хоорондоо уялдаа холбоотой, логик байдлаар зохион байгуулагдсан өгүүлбэрүүдээс бүрддэг бөгөөд уншигчид догол мөрийн санааг хялбархан мэдэх боломжтой байдаг. Зөвхөн нэг гол санаа цогцолборт байдаг ба түүнийг цогц байдлаар гаргах уншигчдад судлаачийн хэлэхийг хүсэж буй ойлголтыг мэдэхэд тусалдаг. Дээрх тодорхойлолтууд нь цогцолбор бол нь нэг гол санааг илэрхийлэхийн тулд зүй тогтлын дагуу зохион байгуулагдсан хэд хэдэн өгүүлбэр бүхий эхийн бүтцийн хамгийн бага нэгж юм гэсэн дүгнэлтэд хүргэдэг. Өөрөөр хэлбэл, сайн догол мөр дэх өгүүлбэрүүд нь хоорондоо нэгдмэл уялдаа холбоотой байх ёстой. Эдгээр өгүүлбэрүүд нь чиглүүлэгч өгүүлбэр, нэмэн дэлгэрүүлэгч, туслах өгүүлбэр болон дүгнэлт өгүүлбэрээс бүрдэнэ.

Цогцолборын бүтэц гэдэг нь өгүүлбэрүүдийг догол мөр болгон бүрдүүлэхийг хэлнэ. Forlini (1987), Warriner (1988) Childs et al. (1999), Beare (2012), Rolls & Wignell (2013) болон Nordquist (2019a) нарын үзэж байгаагаар цогцолбор нь сэдвийн чиглүүлэгч өгүүлбэр, дэмжин туслах өгүүлбэр болон дүгнэлт өгүүлбэрүүдээс бүрдэнэ.

Чиглүүлэгч өгүүлбэр нь цогцолбор дах бусад бүх өгүүлбэрүүдийн үндсэн санааг дэмжин зангидаж буй өгүүлбэр юм. (Forlini et al., 1987; Warriner, 1988; Childs et al., 1999; Beare, 2012; Rolls, N. & Wignell, P. 2013. Ихэнхдээ чиглүүлэгч өгүүлбэр нь догол мөрний эхний өгүүлбэр байдаг ба энэ нь тухайн догол мөрөнд юуны тухай өгүүлж байгааг уншигч ойлгоход дөхөм болгодог (Warriner, 1988). Мөн чиглүүлэгч өгүүлбэр нь догол мөрний дунд эсвэл төгсгөлд гарч болно (Warriner, 1988). Driscoll & Brizee (2010) Warriner-ийн (1988) энэхүү мэдэгдлийг баталсан ба, чиглүүлэгч өгүүлбэр

нь догол мөрний аль ч хэсэгт (эхний өгүүлбэр, сүүлчийн өгүүлбэр, эсвэл дунд хэсэгт) тохиолдож болно гэж үзжээ. Гэсэн хэдий ч уншигчдын хувьд цогцолборын гол санааг хялбар ойлгуулахын тулд чиглүүлэгч өгүүлбэрийг тухайн догол мөрний эхний хэсэгт оруулах нь зөв юм.

Судлаачид цогцолбор нь дэмжин туслах өгүүлбэртэй байх ёстой гэж үзсэн. (Warriner, 1988) Эдгээр туслах өгүүлбэрүүд нь чиглүүлэгч өгүүлбэрийн гол санааг дэмжиж тодорхой мэдээллийг өгдөг. Мөн түүнчлэн чиглүүлэгч өгүүлбэрийг нарийвчилсан тодорхойлолт болон жишээ баримтаар баяжуулдаг (Beare, 2012). Тиймээс дэмжин туслах өгүүлбэрүүд нь догол мөр бүрийн гол санааг хөгжүүлдэг бүтэц юм (Forlini et al., 1987, хуудас. 443-446). Иймд догол мөрийг дэлгэрэнгүй жишээ баримт, шалтгаан, тохиолдлуудаар баяжуулан бичиж болно.

Цогцолбор дах төгсгөлийн дүгнэлт өгүүлбэр нь догол мөрний гурав дах гол хэсэг юм. Төгсгөлийн өгүүлбэрийг бичихдээ холбоос үгийг ашигладаг ба энэ нь догол мөрийг бүрэн төгс болгодог (Warriner, 1988). Тиймээс, цогцолборыг төгсгөхдөө зохиолч тухайн сэдэвт дурдсан үндсэн санааг давтан хэлэх нь чухал юм. Тэгэхдээ ижил утгатай үгээр уг санааг дүгнэн базаж гаргах нь бичвэрийг илүү баялаг болгодог.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд оюутнуудын бичсэн цогцолборт нэгдмэл санаа байгаа эсэх болон ерөнхий бүтцэд нь дүн шинжилгээ хийхэд чиглэсэн агуулгын шинжилгээг ашигласан. Агуулгын шинжилгээ нь тухайн бичвэрт дүн шинжилгээ хийх, дараа нь судалгаатай холбоотой хөгжиж буй зарим онол дээр үндэслэн тэдгээрийг тайлбарлах хэд хэдэн үйл ажиллагааг хамардаг. Уг судалгаанд МУБИС-н НХУС, Англи хэлний багшийн ангийн 6 оюутны бичсэн цогцолборын бүтэц, нэгдмэл санаа гаргасан байдлыг судлахыг зорилоо.

Оюутнууд өөр өөр сэдвүүдийг ашиглан цогцолбор бичжээ. Догол мөрийн сэдвүүд нь: “My hobby”, “My shopping habits” ба “Good teacher” Oshima, A. and Hogue, A. (1991)-ийн хэлснээр оюутан аливаа зүйлийн талаар огт мэдэхгүй байж болох учир тэдэнд ямагт сонголт өгөх хэрэгтэй гэжээ. Тиймээс энэ судалгаанд оюутнуудад нэг биш гурван сэдвийг санал болгосон.

Судалгаанд тухайн цогцолборуудын бүтцийн хэсгүүд нь болох чиглүүлэгч өгүүлбэр, дэмжин туслах өгүүлбэр, эцсийн дүгнэлт өгүүлбэрүүдийг зөв зохион байгуулалттай гаргасан эсэх болон тухайн өгүүлбэрүүд бүгд чиглүүлэгч өгүүлбэртэйгээ нягт уялдаа холбоотой нэгдсэн санааг гаргаж буй эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

Судалгааны хэсэг

Судалгаанд орсон 6 цогцолбороос харахад 5 цогцолбор нь чиглүүлэгч өгүүлбэртэй байлаа. Нэг нь огт чиглүүлэгч өгүүлбэр бичээгүй байв. Бичсэн 5 чиглүүлэгч өгүүлбэрийн 2 нь утга болон бүтцийн хувьд бичсэн цогцолбортоо тохиромжгүй байлаа. Бусад чиглүүлэгч өгүүлбэрүүд нэлээд сайн бичигджээ. Дэмжин туслах өгүүлбэрүүдийг шинжилж үзвэл 4 нь өөрсдийн бичсэн чиглүүлэгч өгүүлбэрийг дэмжих боломжгүй өгүүлбэр бичсэн байлаа. Нэг цогцолборын төгсгөлийн дүгнэлт өгүүлбэр нь чиглүүлэгч өгүүлбэр болон дэмжигч өгүүлбэрийн хэсэгт огт дурдагдаагүй шинэ санаа гаргаж бичжээ. Доорх хүснэгтэд оюутнуудын догол мөрний сайн бүтцийг харуулсан танилцуулгыг харуулав.

Оюутнуудын цогцолбор бичихэд тулгардаг гол бэрхшээлүүдийн нэг нь дэмжин туслах өгүүлбэрийг зөв гаргахад байлаа. Энэ нь ихэнх оюутнууд чиглүүлэгч өгүүлбэр бичих чадвартай ч түүнтэй утга уялдуулан зохих туслан дэмжигч өгүүлбэрүүдийг бичих талаар ойлголт хомс байсантай холбоотой байв. Зарим оюутнууд нэгдсэн утга бүхий догол мөр бичих тал дээр ч сул байлаа. Ер нь оюутнуудын хувьд чиглүүлэгч өгүүлбэрт өгөгдсөн санааг зөв боловсруулан нэмэн дэлгэрүүлэхэд гол бэрхшээлтэй тулгарсан байна.

Доорх өгүүлбэр нь оюутны бичсэн чиглүүлэгч өгүүлбэрийн жишээ юм.

(1) *There are two main characteristics of being good teacher.*

Дээрх жишээг сайн бичигдсэн чиглүүлэгч өгүүлбэр гэж үзэж болно. Чиглүүлэгч өгүүлбэр нь сэдэв болон тодорхой хяналтын санаатай байдаг. Чиглүүлэгч өгүүлбэрийн хяналтын санаа нь цогцолборын үндсэн хэсгийн утгыг хяналттай байлгах үүрэгтэй. Тиймээс уншигчид эхний өгүүлбэрээс л тухайн цогцолборт ямар зүйлс байгааг таамаглаж чаддаг. Жишээлбэл, (1) өгүүлбэрт сэдэв нь “good teacher” бөгөөд хяналтын санаа нь “two main characteristics” бөгөөд уг өгүүлбэрийг уншсанаар уншигч энэ догол мөрөнд сайн багшийн хоёр онцлог шинж чанарын талаар өгүүлэхийг нь урьдчилан мэдэх болно. Бүх туслах өгүүлбэрүүд чиглүүлэгч өгүүлбэрийг дэмжих ёстой. Зохиолч догол мөр бичихдээ хамааралгүй санааг оруулахаас зайлсхийх хэрэгтэй. Доорх жишээнээс харахад бүх өгүүлбэрүүд чиглүүлэгч өгүүлбэрийн санааг дэмжиж байна (1).

(2) *First of all, a good teacher must be patient eventhough dealing with youngsters can be difficult. Because students should feel comfortable talking to their teacher openly and honestly – especially if they face difficulties. Also a teacher is patient enough to listen and understand. Second, a great teacher loves their job and everything about it. This is especially important for students, as feeling a sense of enthusiasm from their teacher will inspire them to learn and apply themselves better.*

Төгсгөлийн дүгнэлт өгүүлбэр нь цогцолборт гарсан нийт санааг багтаан бататгадаг ба түүнийг сайн зангидан гаргаж байж л цогцолбор төгс болно. Дүгнэлт өгүүлбэр бичих хэд хэдэн арга байдаг. Үүнд: цогцолборын гол санааг нэгтгэн дүгнэх, чиглүүлэгч өгүүлбэрийг ижил утга бүхий өөр үгээр орлуулан давтан бичих, цогцолборын үндсэн санаануудыг дэлгэрэнгүй тайлбарлан бичих гэсэн аргууд байна. Доорх өгүүлбэр нь цогцолборын дүгнэлт өгүүлбэр юм.

(3) *All in all, good teacher should be forbearance and eager.*

Дээрх жишээнээс харахад оюутан дүгнэлт өгүүлбэрээ цогцолборын үндсэн санаануудыг тоочих аргаар бичсэн нь чиглүүлэгч өгүүлбэр болон цогцолборын үндсэн санаатай нийцсэн өгүүлбэр болжээ.

Цогцолборт бүхэлдээ зөвхөн нэг санааг (unified) гаргасан байх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, чиглүүлэгч өгүүлбэр, туслан дэмжигч өгүүлбэр, дүгнэлт өгүүлбэрүүд бүгд нэг л зүйлийн талаар өгүүлсэн байна. Дээрх жишээнүүдээс харахад утга хазайсан өгүүлбэр байгаагүй.

Хэлэлцүүлэг

Зарим оюутнууд чиглүүлэгч өгүүлбэр, туслан дэмжигч өгүүлбэр, төгсгөлийн дүгнэлт өгүүлбэр зэрэг цогцолборын үндсэн хэсгүүдийг бичихэд бэрхшээлтэй тулгарсан. Цогцолборын үндсэн бүтэц нь оюутнууд цаашдаа эссэ, өгүүлэл гэх мэт илүү нарийн төвөгтэй зүйлс бичиж эхлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг суурь мэдлэг боловч оюутнууд цогцолбор бичих тал дээр бэрхшээлтэй хэвээр л байна.

Цогцолбор бичихдээ өгүүлэх гэж буй санаагаа хэрхэн хөгжүүлэх, баяжуулах, жишээ баримтаар дэлгэрүүлэх талаар анхаарах ёстой. Үүний тулд чиглүүлэгч өгүүлбэрийн хяналтын хэсгийг ойлгомжтой, тод томруун гаргах ёстой бөгөөд цогцолборын үндсэн хэсгүүдийг гаргахдаа чухам хяналтын хэсгийн хүрээнд л санаагаа гаргах ба жишээ баримтуудаар мөн дэлгэрүүлж болно. Энэ хоёр хэсгийн уялдаа холбоо таарахгүй бол цогцолбор бүхэлдээ эвдэрч нэгэн цогц санааг гаргаж чадахгүйд хүрнэ. Эцэст нь эхний хоёр хэсэг хоорондоо уялдаагүй бол дүгнэлт өгүүлбэр ч гаргах боломжгүй болно.

Дүгнэлт

Ихэнх оюутнууд цогцолборын үндсэн бүтцийн хэсгүүдийг бичих чадвартай байлаа. Гэсэн хэдий ч зарим оюутнууд нэгдмэл нэг санаа бүхий цогцолбор бичих тал дээр алдаа гаргасан хэвээрээ

л байна. Оюутнуудын бичсэн цогцолборт хийсэн дүн шинжилгээнээс харахад тэдний гаргасан алдаанууд үндсэн хоёр гол хүчин зүйлээс шалтгаалсан гэж үзлээ. Үүнд: нэгдүгээрт, ихэнх оюутнууд чиглүүлэгч өгүүлбэрийг бичиж чадсан хэдий боловч түүний гол үүргийг нь ухамсарлан ойлгоогүй. Тухайлбал маш сайн чиглүүлэгч өгүүлбэр бичсэн ч түүнийгээ цогцолборын гол хэсгүүдтэй шууд уялдуулан холбож чадаагүй байв. Эсвэл маш сайн бичигдсэн чиглүүлэгч өгүүлбэр нь дүгнэлт өгүүлбэртэйгээ зөрчилдсөн ч цогцолбор таарч байлаа. Нэг оюутны хувьд түүнийг зөвхөн эхний өгүүлбэрт л орох ёстой гэсэн ойлголттой байв. Мөн нэг оюутан чиглүүлэгч өгүүлбэр огт бичээгүй учир түүний бичвэр нь нэг санаа бүхий нэгдмэл утгатай болж чадаагүйгээс гадна дүгнэлт өгүүлбэр нь тухайн цогцолбортойгоо уялдахгүй байлаа. Хоёрдугаарт, цогцолбор бичихдээ ерөнхийлөн нэгдсэн ганц санааг гаргах тал дээр ойлголтгүй гэхээсээ илүү анхааралгүй хандсан тохиолдол ажиглагдлаа. Чиглүүлэгч өгүүлбэрийн хяналтын хэсэгт хамааралгүй утга бүхий өгүүлбэр хоёр цогцолборт бичигдсэн бол нэг цогцолборын дүгнэлт өгүүлбэрт тухайн бичвэрт дурдагдаагүй цоо шинэ санааг дэвшүүлсэн байлаа. Эцэст нь дүгнэхэд, оюутнуудын бичсэн цогцолборт гаргасан алдаанууд нь цогцолборын ерөнхий бүтэц болох чиглүүлэгч өгүүлбэр, туслан дэмжигч өгүүлбэрүүд ба дүгнэлт өгүүлбэрийн талаар ойлголт тааруу, тэдгээр хэсгүүдийн үндсэн үүрэг болон хоорондын уялдаа холбоог ухамсарлан ойлгоогүйтэй холбоотой гэж үзлээ. Ялангуяа чиглүүлэгч өгүүлбэрийг хэрхэн оновчтой бичихээс шалтгаалан дэмжин туслах өгүүлбэрүүдийн гаргах санаа болон нэмэн дэлгэрүүлэх жишээ баримт нь оновчтой болдог ба цаашлаад маш оновчтой, дэлгэрэнгүй дүгнэлт өгүүлбэр бичих суурь үндэс болох талаар тодорхой мэдлэг дутмаг байна гэж дүгнэлээ. Нэмж хэлэхэд оюутнууд нэгдмэл нэг санаа бүхий цогцолбор бичихдээ түүний өгүүлбэр бүрийн утга санааг анхаарч үзэх хэрэгтэй. Цогцолборын бүх өгүүлбэрүүд ижил санаагаар холбогдох ёстой ба түүнд хамааралгүй өгүүлбэрүүдийг орхих нь зүйтэй.

Analysis on English paragraph written by students

Bayasgalan Tseesed

Department of English and German Languages, Mongolian National University of Education

Ulaanbaatar, Mongolia

Abstract: This research aims to analyze the structure and unity of paragraphs written by undergraduate students at Mongolian National University of Education. The study utilizes the structural components and unity of English paragraphs as a framework. Six students participated in the study, with research data comprising essays in English covering various topics. The findings reveal that students struggle to grasp the concept of a paragraph as a distinct section of writing, typically focusing on a single theme to express a coherent idea about an event. Many students encountered difficulties in composing the structural elements of a paragraph, including crafting a topic sentence, providing supporting details, and concluding effectively. These structural components play a crucial role in developing a unified idea. Furthermore, students commonly made errors such as veering off-topic, including unnecessary sentences, and disrupting the chronological sequence of events in complex writing tasks. Students made errors in composing the supporting and concluding sentences of the paragraph because they lacked comprehension of the primary function of the topic sentence.

Keywords: writing skill, topic sentence, supporting sentence, conclusion

Ном зүй

- Asiah, N., Ardian, E., & Amri, S. (2020). A study on the student's factor difficulty in writing narrative text ar VII grade of MTS Sabilal Muthadin Tembilahan. *J-Shelves of Indragiri (JSI)*, 1(2), 84–97.
- Beare, K. (2012). Paragraph writing. English as second language. Retrieved from www.els.about.com/cs/writing
- Childs, L., Acott-Smith, A., & Curtis, K. (1999). Writing paragraphs and the writing process. *Academic Studies English*. Retrieved from <http://www.nald.ca/library/learning/academic/english/writing>.
- Driscoll, D. L. & Brizee, A. (2010). On paragraphs. Retrieved from www.owl.english.purdue.edu
- Forlini, G., Bauer, M. B., Biener, L., Capo, L., Kenyon, K. M., Shaw, D. H., & Verner, Z. (1987). *Grammar and composition* (3rd ed.). Englewood Cliffs, New Jersey: Prentice-Hall, Inc.
- Jayanti, A. D. (2019). Students' Writing Ability on English Descriptive Text at Grade VIII. *Academic Journal of English Language and Education*, 3(1), 71–94.
- Kirzner, L. G. & Mandell, S. R. (2007). *The Holt handbook* (4th ed.). Fort Worth: Harcourt Brace College Publishers.
- Langan, J. (2001). *College writing skills with readings* (5th ed.). New York, USA: McGraw-Hill Companies Inc.
- Latief, M. A. (1990). Assessment of English writing skills for students of English as a Foreign language at the institute of teacher training and education (IKIP - Malang) Indonesia
- Lunsford, A. & Connors, R. (1995). *The St. Martin's handbook – Annotated instructor's edition*. New York, USA: St. Martins.
- Ningsih, S. (2016). Guided Writing to Improve the Students' Writing Ability of Junior High School Students. *Efl Journal*, 1(2), 129–140. <https://doi.org/10.21462/eflj.v1i2.12>.
- Nordquist, R. (2019a). Definitions and examples of paragraphing in essays. Retrieved from <https://www.thoughtcom.com/paragraphing-composition-term-1691483>
- Oshima, A. and Hogue, A. 1991. *Writing Academic English*. Third Edition. New York: Addison Wesley Longman
- Rolls, N. & Wignell, P. (2013). *Communicating at university: Skills for success*. Darton, Australia, Charles Darwin University Press
- Stern, A. A. (1976). When is a paragraph? *College Composition and Communication*, Vol. 27, No. 3, 253-257. Retrieved from <http://www.jstor.org/stable/357044>
- Warriner, J. E. (1988). *English composition and grammar: Second course* (Benchmark ed.). Florida: Harcourt Brace Jovanovich, Inc.